

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
НЭГДҮГЭЭР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2019.12.11-2020.01.31/

2020 оны 01 дүгээр сарын 31

Даланзадгад хот

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэлээр:

Виз олголтын талаар:

Тайлант хугацаанд “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу виз олгоход шаардлагатай бичиг баримтыг биедээ авч явсан БНХАУ-ын нийт 19 иргэнд зохих ангиллын визийг олгож, тэмдэгтийн хураамжийн 1.868.000 /нэг сая найман зуун жаран найман мянга/ төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын дансанд тус тус тушаалган ажилласан болно.

- Н / single-entry /-1
- НG /multiple-re-entry/-2
- НG /single-re-entry/-16

Виз хүчингүй болгосон талаар:

“Монгол Улсын Виз олгох журам”-ын 5.2-т заасны дагуу БНХАУ-ын 6 иргэний визийг хүчингүй болгосон.

1.2 Тайлант хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчсон БНХАУ-ын нийт 2370 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

Орох чиглэлд:1009

Гарах чиглэлд:1361

Гашуунсухайт боомт

- Орох чиглэл -732
- Гарах чиглэл-981

Шивээхүрэн боомт

- Орох чиглэл –277
- Гарах чиглэл-380

1.3 Түр ирэгчийн бүртгэл, хасалт:

Тайлант хугацаанд 2 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 1 иргэний хасалт, БНХАУ-ын 33 иргэнд оршин суух зөвшөөрлийн хасалт хийж ажилласан байна.

1.4 ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 86 иргэнийг бүртгэж, 88 иргэнд хасалт тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.

1.5 Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэдийн талаар:

Гашуунсухайт авто замын боомтоор “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, “Монгол Улсын виз олгох журам”-ын 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 10 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан.

1.6 Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн БНХАУ-ын 27 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч төвд хүргүүлсэн.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Хүний нөөцийн програмд 20 албан хаагчийн цалин, төрийн захиргааны 9 албан хаагчийн төрийн албанд ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг дэв, төрийн үйлчилгээний 6 албан хаагчийн ур чадварын нэмэгдэл зэрэг мэдээллийг тухай бүр нь шивж ажилласан.

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/15 дугаар тушаалаар бүсийн газрын албан хаагчдын цугларалтыг 12 дугаар сарын 21-ний өдөр Даланзадгад хотноо зохион байгууллаа. Энэ үеэр бүсийн газрын дарга 2019 оны ажлын үр дүнг албан хаагчдад танилцуулж, газрын хэмжээнд 2020 онд хийж хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, санал солилцлоо.

Гадаадын иргэн, харьяатын газрын “Удирдах албан тушаалтан, албан хаагчдын цугларалт, сургалт” энэ сарын 20-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо болж өндөрлөлөө. Байгууллагын зорилго, зорилт, тэдгээрийн биелэлт өнгөрсөн онд хийж хэрэгжүүлсэн ажлаа дүгнэж, 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтыг тодорхойлох зорилготой энэхүү цугларалтад тус газрын дарга, захиргааны ахлах мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч нар оролцлоо. Мөн энэ үеэр бүсийн газрын 9 төрийн жинхэнэ албан хаагчийн 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг үнэлгээний багаар амжилттай дүгнүүллээ.

2.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/-1
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-1
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-9/
- Төв газарт явуулсан бичиг /илтгэх хуудас-11/
- Явуулсан бичиг /албан тоот-28/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг-15
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

2.2.Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 01 дүгээр сард, 39347200 төгрөгийн санхүүжилт авч нийт 20 албан хаагчийн цалинд 20219609 төгрөгийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлд 2619851 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 1646438 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 2269130 төгрөг, урсгал засварын зардалд 315000 төгрөг, томилолтын зардалд 897000 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 433000 төгрөгийн гүйлгээ хийж

Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.

Тус газрын 2019 оны 12 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

2.3.Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд гадаад сүлжээнд холбогдсон 8 компьютерийн хаягийн өөрчлөлтийг хийж ажилласан.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР